



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 21/278

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн Засаг даргын
Тамгын газрын данс бүртгэлээс
тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/614 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, эзэмшигч байгууллагад нь сэлбэгийн зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэгдсэн нийт 359,424,000 (гурван зуун тавин есөн сая дөрвөн зуун хорин дөрвөн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тээврийн хэрэгслүүдийг хавсралтын дагуу данс бүртгэлээсээ хасахыг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар (П.Баянбаатар)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслүүдийг сэлбэгийн зориулалтаар фондолж, ашиглалтын шаардлага хангахгүй болон илүүдэлтэй сэлбэгүүдийг хоёрдогч түүхий эд, сэлбэгийн зориулалтаар 3,000,000 (гурван сая) төгрөгөөс доошгүй үнээр худалдан борлуулж зохих дансанд нь орлого болгон авахыг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар (П.Баянбаатар)-т үүрэг болгосугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар (П.Баянбаатар)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т тус тус даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000819



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны дугаар сарын -ны өдрийн дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах тээврийн хэрэгслийн жагсаалт

д/д	Байгууллагын нэр	Автомашины марк, улсын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Бүртгэлд тусгах үнэ
1	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар	Мицубиши 72-28 УБЕ	119,808,000.0	119,808,000.0	0.0	1,000,000.0
2		Мицубиши 72-20 УБЕ	119,808,000.0	119,808,000.0	0.0	1,000,000.0
3		Мицубиши 72-38 УБЕ	119,808,000.0	119,808,000.0	0.0	1,000,000.0
Дүн			359,424,000.0	359,424,000.0	0.0	3,000,000.0

/төгрөгөөр/